# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БАЯСГАЛАНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх зорилт”-ын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жилд:<br>1.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулсан байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын үечилсэн төлөвлөгөө боловсруулна.<br>2.Хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | “Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах явцад Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 3-т “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 1-д “Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” тус тус заасан тул тус хөтөлбөрийг “Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” гэж болгон дахин өөрчилсөн. Мөн төсөл | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж шаардах төсвийг Санхүү хөрөнгө оруулалтын газар, хөтөлбөрийн 2.1-д заасан арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сургалтын төвөөс саналыг авч төсөлд тус тус тусгасан.<br>Тус хөтөлбөрийн төслийг 2023 оны 11 дүгээр сараас хойш хийж гүйцэтгэсэн ажлаа 3 удаа удирдлагад танилцуулж, зөвлөмж, чиглэл авч ажилласан ба эцсийн байдлаар 4 хэсэг 14 заалт бүхий 3 зорилт арга хэмжээний хүрээнд боловсруулан Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлүүлсэн. | | |
| 2. | Албан хаагчдыг шилжүүлэн ажиллуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Мэдээлэл технологийн газарт шилжүүлсэн“ цахим аргачлал”-ын программын даалгаврыг хүлээн авч, эхлүүлсэн байна. Сул орон тооны нөхөн хангалтыг хийнэ. | Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/367 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам”-ын цахим аргачлалын программын даалгаврыг Мэдээлэл технологийн газарт 2023 онд хүлээлгэн өгсөн бөгөөд 2024 онд 2 удаа нэмэлтээр саналаа өгч хамтарсан уулзалт хийж туршилт хийсэн.<br>Уг журмын хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 20-26-ны хооронд захиргаа, дотоод ажлын систем (CERP)-ээр “Б”, “В” бүсэд ажиллаж буй албан хаагчдаас шилжих болон үргэлжлүүлэн ажиллах эсэх хүсэлтийг хүлээн авч холбогдох ажиллагааг хийсэн. Тухайлбал: Гаалийн байгууллагын “Б”, “В” бүсэд хамаарах 15 гаалийн | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар, хорооноос нийт 14 газар, хорооны 147 албан хаагч хүсэлт ирүүлснээс "Б" бүсийн 69 албан хаагч, "В" бүсийн 8 албан хаагч, нийт 77 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах, "Б" бүсийн 32, "В" бүсийн 38 албан хаагч, нийт 70 албан хаагч өөр гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн харин "Б", "В" бүсэд 15 гаалийн газар, хороод багтах бөгөөд одоо ажиллаж байгаа 597 төрийн тусгай албан хаагчдын 25 хувь буюу 147 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах эсвэл харьяа гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн бол "Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам"-ын 3.4-т "Б", "В" бүсэд ажиллах хугацааг 3 хүртэлх жилээр өөрийн хүсэлтээр сунгаж болно" гэсэн заалтын дагуу үргэлжлүүлэн ажиллахаар 77 албан хаагчийн гаргасан хүсэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт цахим мэдээллийн сангийн баяжилт, ашиглалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | 1.Хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллана.<br>2.Албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийн мэдээллийг шинэчлэлийг ХНУМСТ-д оруулна.<br>3.Хувийн хэргийн баяжилтыг хийнэ. | Тайлант хугацаанд нийт 122804 /давхардсан тоогоор/ албан хаагчийн хувийн хэрэгт 31532 хуудас материал баяжилт, 369 албан хаагчийн 20044 хуудас холбогдох материал, 104 боть хадгаламжийг Гаалийн ерөнхий газрын архивт хүлээлгэн өгсөн.<br>Архивд шилжүүлэхээр 2019-2023 онуудыг хамарсан 320 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарсан 67 албан хаагчийн 30 боть, нас барсан 20 ажилтны 8 боть, ажлаас чөлөөлөгдсөн 215 ажилтны 35 боть, халагдсан 18 ажилтны 6 боть нийт 79 боть хадгаламжийн нэгж баримтыг архивт хүлээлгэн өгсөн.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн "Албан хаагчдад зэрэг дэв" Б/10 дугаар тушаалын дагуу 59 албан хаагчийн зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн, Гаалийн ерөнхий газарт /Бүрдүүлэлтийн цахим төв г.м/ 2024 онд томилогдсон 60 албан хаагчийн үндсэн мэдээлэл болон үндсэн цалин, нэмэгдлийн /300 гаран нэмэгдэл/ мэдээллийг тушаалтай хавсарган оруулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |
| 4. | Албан хаагчдын "Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг" | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Нийтийн албанд томилогдсон тухай бүр ХАСХОМ-г нээж, мэдүүлгийг хүлээн авч, баталгаажуулсан байна.<br>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагчийн ХАСУМ-г тухай бүр АТГ-т хянуулж, зөрчил дутагдалгүй ажиллана. | "Авлигын эсрэг хуулийн 10.3. Гаалийн байгууллага нийт 1,447 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, тайланг нэгтгэн энэ оны 02 дугаар сарын 26-ны өдөр 01/714 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Мөн энэ хуулийн 10.4. Тайлангийн хугацаанд 3 албан хаагч их хэмжээний өөрчлөлт | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдүүлж, цахим санд баталгаажуулав. Гаалийн байгууллагад томилогдохоор шинээр, шилжин болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 502 албан хаагчийн ХАСУМ-ийг шинээр нээж, бүртгэл хөтлөн холбогдох материалын хамт 66 удаагийн албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж,496 ХАСУМ хянагдан ирснээс 3 зөрчилтэй, 17 зөрчил үүсч болзошгүйг анхааруулсан, 1 мэдлүүгийг буцаасан. Зөрчилтэй дүгнэлт ирсэн 3 албан хаагчаас 2, анхааруулсан 17 албан хаагчаас 2, нийт 4 албан хаагчийг албан тушаалд томилохоос татгалзсан байна. Мөн шинээр томилогдож байгаа ажилтнаас үйл ажиллагаандаа ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах баталгааны хуудас болон Захиргааны ерөнхий хуулиар Захиргааны шийдвэр, албан хаагчдын хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой асуудлаар тухай бүр сонсох ажиллагааг хийж, оролцогчийн саналыг тусгаж байгаа бөгөөд захиргааны шийдвэрийн төсөлд үндэслэл хэсгийг тусган төслийг хянах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаараа мэдэгдэн гарын үсэг зурж баталгаажуулсан. | | |
| 5. | Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа /сул орон тоо/ | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | 1.Тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулж, сул орон тоог зарласан байна. | Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөн хангахаар Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Гаалийн ерөнхий газрын | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулсан байна. | Салбар зөвлөлөөс олон нийтэд нээлттэй тусгай шалгалтыг 4 удаа 1, 4, 7, 11 дүгээр саруудад зарлаж, бүртгэлд цахимаар 619 иргэн хүсэлт ирүүлснээс шаардлага хангасан 328 иргэнийг бүртгэлд хамруулж, зарлагдсан 533 ажлын байрны 183 сул орон тоон дээр удирдах 3, гүйцэтгэх албан тушаалд дээр 180 иргэн тэнцэн 34,3 хувийг нөхснөөс Улаанбаатар хотод 30 буюу 16,7 хувь, орон нутагт 150 буюу 83,3 хувь нөхлөө. Сул орон тоог нөхөх зорилгоор төрийн өөр байгууллагад ажиллаж байсан 30 төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэн авч ажиллуулсан бөгөөд үүнээс 7 буюу 23 хувийг Улаанбаатар хотод, 23 буюу 77 хувийг орон нутаг дахь харьяа гаалийн газар, хороодод томилон шийдвэрлүүллээ. Олон нийтэд сурталчлан таниулах ажлаар лайк-1230, сэтгэгдэл-103 /сөрөг-10, эерэг-70, нейтрал-13/, шэйр-277, хандалт-2016000 тус тус авсан байна.<br>Албан хаагчийг сургаж чадавхжуулах зорилгоор Удирдлагын академийн эрхэлсэн түшмэл багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 64, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 14 /хувийн зардлаар/, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 7 /улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсвийн санхүүжилтээр/ албан хаагчийг тус тус хамруулсан. | | |
| 6. | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил | | | 1."Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх журам"-ыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн, зохицуулалтыг илүү тодорхой болгох зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>2.Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 жил түүнээс дээш жил ажилласан албан хаагчдад 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох ажлын болзол, шаардлага хангасан тохиолдолд тухай бүр түргэн шуурхай шийдвэрлүүлж ажиллана.<br>3.Албан хаагчдын нийгмийн асуудалтай /шагнал, цол, тусламж, тэтгэмж, цалин нэмэгдэл, урамшуулал, бусад/ холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана | Захиргааны удирдлагын газрын даргаас өгсөн үүргийн дагуу Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/458 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх журам"-ын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, харьяа гаалийн газар, хороодоос 116 санал ирүүлснийг нэгтгэж, энэ оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлаас өгсөн чиглэлийн дагуу төслийг дахин бэлтгэж, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/474 дүгээр тушаалаар 43 нэмэлт, өөрчлөлт оруулж, тодорхойлолтын загварыг хавсралтаар батлуулсан.<br>Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлийн 280.7 дэх хэсэгт Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгох шийдвэр гарсантай холбогдуулан тооцоо судалгааг гаргаж Гаалийн ерөнхий газрын даргын 27 удаагийн тушаалаар нийт 552 албан хаагчид 7.2 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгуулахаар шийдвэрийг гаргуулсан.<br>Тайлангийн хугацаанд 383 албан хаагчийг шагналд нэр дэвшүүлж ирүүлсэн албан хаагчдын | 2024.01.01-2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | материалыг нэгтгэн, удирдлагад танилцуулж 315 албан хаагчийг шагнаж урамшуулах, шагналд нэр дэвшүүлж дээд шатны байгууллагад уламжлахаар шийдвэрлэсэн байна. Энэ нь нийт шагналд нэр дэвшигдэж ирсэн албан хаагчдын 82,2 хувийг дэмжиж шийдвэрлэсэн. Үүнд:<br>1. “Хүндэт гаальчин” тэмдэгээр 20, Гаалийн ерөнхий газрын даргын “Жуух бичиг”-ээр 58, албан тушаалын үндсэн цалингийн 50, 100 хувиар шагнах 14, нийт 92 албан хаагчийг Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар,<br>2. “Гаалийн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 23, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 64, нийт 88 албан хаагчийг Сангийн яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж, холбогдох материалыг Сангийн яаманд хүргүүлэн нийт 87 албан хаагчийг шагнуулсан.<br>Мөн Үндэсний их баяр наадам, Улс тунхагласны ойн баяр, Гаалийн байгууллагын тэмдэглэлт өдрийг тохиолдуулан “Үйлчилгээний гавьяат ажилтан” 1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор 25, “Алтангадас” одонгоор 29, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 80, нийт 135 албан хаагчийг төрийн одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж Сангийн яаманд хүргүүлсэн.<br>“Гаалийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан нийт 155 албан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчид цол олгуулах саналтай холбогдох материал ирүүлснийг нэгтгэн удирдлагуудад танилцуулж, 61 албан хаагчид цол олгох болон сэргээн олгохоор шийдвэрлэсэн. Энэ нь нийт цол олгуулах саналтай ирсэн албан хаагчдын 39,4 хувьд цол олгохоор шийдвэрлэсэн. Үүнд: 36 албан хаагчид "гаалийн зөвлөх", 22 албан хаагчид "гаалийн итгэмжит зөвлөх" цол шинээр олгож, 2 албан хаагчийн урьд авсан "гаалийн зөвлөх", 1 албан хаагчийн "гаалийн итгэмжит зөвлөх" цолыг сэргээн олгосон. | | |
| **Зорилт 2. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах зорилт"-ын хүрээнд** | | | | | | | |
| 1. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт хангах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг хангаж ажилласан байна. | ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг хангаж ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалт, байгууллагаас зохион байгуулсан сургалт мэдээлэлд хамрагдах | | | Байгууллагаас зохион байгуулсан сургалт, мэдээлэлд бүрэн хамрагдана. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 14 удаа хамрагдсан. | 2024.01.01 2024.12.01 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ....................../Ж.Баясгалан/ 09. 12. 2024

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

07

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БАЯСГАЛАНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хүний нөөцийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн биелэлтийн төлөвлөгөөний биелэлт | | 63,97 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалт, байгууллагаас зохион байгуулсан сургалт мэдээлэлд хамрагдах | | 14,8 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 14,8 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 13 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 14 |
| 4 | Манлайлах | 10 |
| 5 | Багаар ажиллах | 12 |
| 6 | Харилцаа | 13 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | – |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | — |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо:** | | 12,5 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 63,97 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14,8 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 12,5 |
| 4 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | — |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 91,3 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга .................... (Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .................... (Ж.Баясгалан)

2024.12.20 (огноо)